



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2022 оны 03 сарын 18 өдөр

Дугаар А/149

Улаанбаатар хот

Амиа хорлох оролдлого хийсэн хүүхэд,
өсвөр үеийнхэнд эрүүл мэндийн тусламж,
үйлчилгээ үзүүлэх заавар батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.24, Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийн 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Амиа хорлох оролдлого хийсэн хүүхэд, өсвөр үеийнхэнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх заавар”-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэ тушаалаар батлагдсан заавруудыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавьж, ажиллахыг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга нарт, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг төрийн болон хувийн хэвшлийн бүх шатны эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт даалгасугай.

3. Тус тушаалыг хэрэгжүүлэхэд улсын хэмжээнд сэтгэцийн эмгэгээс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, оношлох, эмчлэх, сэтгэц-нийгмийн нөхөн сэргээх тусламж, үйлчилгээ үзүүлэх, мэргэжил, арга зүйгээр хангах, үйл ажиллагаанд нь хяналт тавихыг Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв /Л.Насанцэнгэл/-д үүрэг болгосугай.

4. Энэхүү зааврыг хэрэгжүүлэхэд шаардагдах хүний нөөц, санхүүжилтийг батлагдсан төсвийнхөө хүрээнд багтаан шийдвэрлэж, хэрэгжилтийг ханган ажиллахыг өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.


САЙД



С.ЭНХБОЛД

141220784

Эрүүл мэндийн сайдын 2022 оны 03 сарын 18 өдрийн 14 дугаар тушаалын хавсралт



АМИА ХОРЛОХ ОРОЛДЛОГО ХИЙСЭН ХҮҮХЭД, ӨСВӨР ҮЕИЙНХЭНД ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЗААВАР

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Өвчний код (Өвчний олон улсын – 10 ангилал)

X60 – X84 кодоор “Зориуд санаатайгаар өөрийгөө хорлох” гэсэн хэсгийг, хэрэв амиа хорлосон болон амиа хорлох оролдлого хийгч нь сэтгэцийн эмгэгийн улмаас амиа хорлох үйлдлийг хийсэн бол Өвчний олон улсын X ангиллын гарын авлагын F бүлгийн оношийн кодыг ашиглана.

1.2 Зааврын зорилго, зорилт:

Өсвөр үеийнхнийг амиа хорлохоос урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, амиа хорлох төрх үйлд өртөх эрсдэл, эрсдэлийн түвшинг бууруулахад чиглэнэ.

Зорилтууд:

1. Амиа хорлох төрх үйлийн талаарх хүн амын болон эрүүл мэндийн ажилтны мэдлэгийг дээшлүүлэн, эрт илрүүлэлтийг эрчимжүүлэх
2. Амиа хорлох төрх үйлийн оношилгоо, эмчилгээ, хяналтыг сайжруулах
3. Амиа хорлох оролдлогоос шалтгаалсан эрсдэлийг үнэлж, эрсдэлийн түвшинг бууруулахад чиглэсэн бодлого, үйл ажиллагааг явуулах.

1.3. Ашигласан нэр томъёо, тодорхойлолт:

1. *Амиа хорлох үзэгдэл* - олон улсын эмнэлгийн нэр томъёогоор зориуд санаатайгаар амиа бүрмөсөн хөнөөх үйлдэл болон амиа хорлох оролдлого хийх үйлдлийг нэгтгэсэн ойлголт;
2. *Амиа хорлох бодол* – Тухайн хүнд үхэх зурс хийсэн бодлоос эхлээд өдөр бүр үхэх тухай улигт бодол төрөх хүртэл тодорхой хугацааны турш үргэлжилдэг үйл явц
3. *Амиа хорлох төсөөлөл* – Өөрийн амиа хорлож байгаа дүр зургийг дахин дахин толгойдоо дүрслэн зурж төсөөлөх, буюу ирээдүйд өөрийгөө хэрхэн амиа хорлож үхэж байгаагаа төсөөлж харах
4. *Амиа хорлох төлөвлөгөө* – Амиа хорлох төсөөллөө хэрэгжүүлэх хүчтэй дур хүсэл төрдөг бөгөөд амиа хорлох аргаа сонгож түүнийгээ хэрэгжүүлэхэд зугуухан бэлтгэх
5. *Амиа хорлох үйл явц* - амиа хорлох бодол биелэлээ олж, амиа хорлохыг завдсан үйлдэл болон санаатайгаар өөрийн амийг бүрмөсөн хөнөөх үйлдэл үйлдэгдэхийг хамруулсан үйл явц.
6. *Далд амиа хорлолт* - зуурдын гэнэтийн шалтгаан тодорхойгүй зарим нас баралтыг энэ ойлголтод хамааруулан ойлгоно. Тухайлбал, машинд дайруулах, усанд живэх, өндрөөс унах гэх мэт.
7. *Хамтын амиа хорлолт* - хамтдаа үгсэн тохирч амиа хорлож нас барсан тохиолдлууд

8. *Даган дууриах амиа хорлолт* - өөрийн шүтэн биширдэг олны танил, нэрд гарсан хүмүүсийн амиа хорлосон үйлдлийг даган дууриан өөрийгөө хөнөөх хэлбэр. Тухайлбал: Вертерийн хам шинж, Мерилин Монрогийн хам шинж гэх мэт
9. *Өвчний олон улсын ангилал “Зориуд санаатайгаар өөрийгөө хорлох Х60- Х84”* – Эрүүл мэндийн практикт тохиолдох бүхий л өвчлөлийг тодорхой шалгуурын дагуу ангилан бүлэглэсэн тогтолцоо бөгөөд бичгээр илэрхийлсэн амиа хорлох үзэгдлийн оношийг үсэг тоогоор илэрхийлэх кодонд шилжүүлснээр мэдээг хадгалах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх ажлыг хялбаршуулсан хэлбэр юм. Энэхүү ангилал нь Өвчний олон улсын 10 дугаар ангиллаас салбарласан ангилал бөгөөд бүртгэл мэдээлэл тусламжийн тогтолцоонд хэрэглэгдэнэ.
10. *Амиа хорлох үзэгдлийн тархалт* – өмнөх онд бүртгэгдсэн амиа хорлох оролдлого хийсэн хүний тоо ба тухайн жилд шинээр бүртгэгдсэн амиа хорлох үзэгдлийн нийт тохиолдлын нийлбэр
11. *Амиа хорлолтын түвшин* - тухайн жилийн 100000 хүн амд ноогдох амиа хорлох үзэгдлийн шинээр бүртгэгдсэн тохиолдлын тоо бөгөөд нийт тохиолдлын тоог 100000 хүн амд үржүүлж нийт хүн амын тоонд харьцуулсан үзүүлэлт

1.6. Үндсэн ойлголт

Амиа хорлох (Suicide or suicidal behavior) гэдэг нь хэн нэгэн санаатайгаар өөрийн амийг таслах төрх үйл юм. Олон улсын эмнэлгийн нэр томъёогоор зориуд амиа бүрмөсөн хорлох үйлдлийг суицид, амиа хорлох оролдлого хийх тохиолдлыг парасуицид хэмээн нэрлэдэг. ДЭМБ-ын тогтоосноор тухайн оронд амиа хорлогсдын тоо 100 000 хүн ам тутамд 10-аас бага байх нь нам үзүүлэлт, 20-оос дээш байх нь өндөр, 25-аас дээш байх нь хэт өндөр үзүүлэлт ба 2018 оны байдлаар дэлхийн дундаж түвшин 100000 хүн амд 10.5 байсан. 2016 онд манай улсын амиа хорлолтын түвшин 13.3 (эрэгтэйд 23.3, эмэгтэйд 3.8) ба дэлхийд 40 байрт орсон.

Амиа хорлох төрх үйл гэдэг нь хүн санаатайгаар өөрийн эрүүл мэнд, амь насанд аюул учруулж буй үйлдэл бөгөөд үүнд:

- Амиа хорлох бодол төрөх
- Амиа хорлолтыг төсөөлөх
- Амиа хорлох төлөвлөгөө зохиох буюу төлөвлөх, үйлдлийн аргаа сонгох
- Амиа хорлох үйлдэл хийх
- Амиа хорлох төрх үйл зэрэг нь хамаарна.

Амиа хорлох, амиа хорлох оролдлого хийж буй хүмүүсийн сэтгэцийн эрүүл мэндийн байдлыг харгалзан:

1. Сэтгэцийн хувьд эрүүл боловч нийгэм сэтгэлзүйн ямар нэгэн тулгамдсан асуудалтай хүмүүс
2. Сэтгэцийн эмгэгтэй хүмүүс хэмээн 2 ангилж болно.

Хүүхэд, өсвөр үеийнхэн амиа хорлох, амиа хорлох оролдлого хийх шалтгаан, нөлөөлөх хүчин зүйлс:

- Гэр бүлийн зөрчил, маргаан, эцэг эх нь салсан, санхүүгийн асуудал
- Гэр оронгүй болсон, ганцаардсан
- Буруу хүмүүжил
- Биеийн болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн
- Ойр дотны хүмүүс нь хүндээр өвдсөн буюу нас барсан
- Сургууль, багш, үе тэнгийн дарамт, шахалт
- Үерхэл нөхөрлөл бүтэлгүйтэх

- Гэмт хэрэгт холбогдох
- Өсвөр насны охидын хүсээгүй жирэмслэлт
- Архи, тамхи бусад мансууруулах бодис хэрэглэх, интернэт тоглоомонд донтох
- Биеийн хүнд өвчнөөр өвдөх
- Удамд нь сэтгэцийн эмгэгтэй, амиа хорлосон, амиа хорлох оролдлого хийж байсан хүн байдаг
- Сэтгэцийн эмгэгтэй ялангуяа сэтгэл гутрах эмгэгтэй
- Урьд нь амиа хорлох оролдлого хийж байсан
- Даган дуурайх сэдэл
- Төрх үйлийн өөрчлөлттэй холбоотой (Жишээ нь: Гарын судсанд зүслэг хийж, амьсгалаа боогдуулах, өндрөөс үсрэх, биедээ гэмтэл учруулах, цус гаргах)

Хүүхэд, өсвөр үеийнхнийг амиа хорлох, амиа хорлох оролдлого хийхээс хамгаалах хүчин зүйлс:

- Амьдрах ур чадвар (асуудлыг шийдвэрлэх, стрессийг даван туулах чадвар)
- Гэр бүл, найз нөхөд, бусад хүмүүсийн дэмжлэг
- Сургуулийн эерэг, таатай орчин

ХОЁР. ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭНИЙ ДЭС ДАРААЛАЛ

2.1 Амиа хорлох оролдлого хийж болзошгүй шинж тэмдэг

Өсвөр насны хүүхдүүдийн амиа хорлох оролдлого хийж болзошгүй шинж тэмдгийн 75% нь уг яриа, төрх үйлээр илэрдэг. Эдгээр шинж тэмдгүүдийг ерөнхий мэргэжлийн эмч, өсвөрийн эмч, сэтгэцийн эмч, сэтгэл засалч эмч мэдсэнээр амиа хорлох үйлдлээс хүүхдийг сэргийлэх боломжтой байдаг.

- Үхлийн тухай болон амиа хорлох тухай байнга ярих буюу асуух
- Амиа хорлох, өөрийгөө гэмтээх аргын тухай сонирхох, судлах
- Зүсэх багаж хэрэгслийг цуглуулах
- Бусдын төлөө санаа зовдог
- Хувийн дуртай зүйлээ хаях эсвэл хүнд өгөх, оршуулга зохион байгуулах
- Сэтгэл түгших, санаа зовинох
- Сэтгэлээр унаж гутрах, өөрийгөө буруутгах
- Ганцаараа үлдэхийг илүүд үзнэ, зожиг болох
- Уурлаж бухимдах
- Зарим үед шалтгаангүй чанга инээх
- Амьдралын тодорхой зорилгогүй
- Нойрны өөрчлөлт
- Сэтгэц идэвхит бодисын хэрэглэх нь ихсэх

2.2 Амиа хорлох бодлыг илрүүлэх асуумж, сорилууд:

Хүүхэд, өсвөр насныханд өөрийгөө үнэлэх сэтгэл гутралыг илрүүлэх 9 асуулт бүхий сорил (PHQ-9)-ыг хэрэглэх ба уг сорилд амиа хорлох бодлыг илрүүлэх 1 асуулт багтдаг. Сорилын мэдрэг чанар 61% ба өвөрмөц байдал нь 94% байна. Сорилын найдвартай байдлыг Коренбахын альфа коэффициентээр үнэлэхэд 0.85 байв.

Сэтгэл гутралыг илрүүлэх асуумж (PHQ-9)

| /Өнгөрсөн 2 долоо хоногийн хугацаанд доорх асуудлууд танд хэр зэрэг түвэг удсан тухай бодож, тохирох тоог дугуйлаарай/ | | |
|--|---|---|
| 1. | Хийж буй зүйлдээ сэтгэл хангалуун бус эсвэл идэвхи сонирхол буурдаг уу? | Огт үгүй -0 Заримдаа -1 Ихэнхидээ -2 Үргэлж, өдөр бүр -3 |
| 2. | Мэдрэмж бууран сэтгэлээр унах эсвэл итгэл найдвар тасардаг уу? | Огт үгүй -0 Заримдаа -1 Ихэнхидээ -2 Үргэлж, өдөр бүр -3 |
| 3. | Орой унтахад түвэгтэй эсвэл хэт их унтдаг уу? | Огт үгүй -0 Заримдаа -1 Ихэнхидээ -2 Үргэлж, өдөр бүр -3 |
| 4. | Ядрах эсвэл эрч хүчээ алдсан мэт мэдрэмж төрдөг үү? | Огт үгүй -0 Заримдаа -1 Ихэнхидээ -2 Үргэлж, өдөр бүр -3 |
| 5. | Хоолны дуршил буурах эсвэл хэт иддэг үү? | Огт үгүй -0 Заримдаа -1 Ихэнхидээ -2 Үргэлж, өдөр бүр -3 |
| 6. | Өөрийгөө муугаар бодож, бүтэлгүй мэт санаж, өөртөө болон гэр бүлдээ сэтгэл гонсойдог уу? | Огт үгүй -0 Заримдаа -1 Ихэнхидээ -2 Үргэлж, өдөр бүр -3 |
| 7. | Ямар нэг зүйлд анхаарлаа төвлөрүүлэхэд түвэгтэй байдаг уу? (ном унших, зурагт үзэх гэх мэт) | Огт үгүй -0 Заримдаа -1 Ихэнхидээ -2 Үргэлж, өдөр бүр -3 |
| 8. | Бусад хүмүүс таныг удаан хөдлөж, удаан ярьж байна гэж хэлэх эсвэл ердийнхөөсөө илүү тайван бус, тогтворгүй байна гэж хэлдэг үү? | Огт үгүй -0 Заримдаа -1 Ихэнхидээ -2 Үргэлж, өдөр бүр -3 |
| 9. | Өөрийгөө гэмтээх эсвэл ингэж амьдрахаар үхсэн нь дээр гэж бодож байсан уу? | Огт үгүй -0 Заримдаа -1 Ихэнхидээ -2 Үргэлж, өдөр бүр -3 |

Сорилын оноо:

- 0-9 бол сэтгэл гутралгүй
- 10-аас дээш бол сэтгэл гутралтай гэж үнэлнэ.

Амиа хорлох эрсдлийг илрүүлэх асуумж

1990 онд анх удаа Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас боловсруулсан амиа хорлох бодол, төлөвлөгөө, үйлдэл байгаа эсэхийг илрүүлэх 4 асуулт бүхий асуумж юм.

| | | |
|----|--|--------------------|
| 1. | Хэзээ нэгэн цагт амьдрал утгагүй мэт санагдаж, үхэх талаар бодож байсан уу? | Тийм -1 Үгүй -2 |
| 2. | Хэзээ нэгэн цагт амиа хорлох төлөвлөгөө боловсруулж, түүнийгээ хэрэгжүүлэх алхам хийж байсан уу? | Тийм -1 Үгүй -2 |
| 3. | Хэзээ нэгэн цагт амиа хорлох оролдлого, үйлдэл хийж байсан уу? | Тийм -1 Үгүй -2 |
| 4. | Хэрэв тийм бол хэдэн удаа оролдого хийж байсан бэ? | |

Хэрэв 1 асуултанд л тийм гэж хариулсан бол амиа хорлох эрсдэлтэй гэж үнэлнэ. Хүүхэд, өсвөр насныхан амиа хорлох бодлынхоо талаар ярьж эхэлвэл эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд нээлттэй, итгэлтэй харилцаагаа үргэлжлүүлэн хадгалах хэрэгтэй.

Амиа хорлох эрсдлийг үнэлэхдээ амиа хорлох бодол, төсөөлөл, төлөвлөгөө зэргийг нийтэд нь үнэлэх хэрэгтэй. Үүнд:

- Амиа хорлох бодол, үргэлжлэх хугацаа
- Амиа хорлох төлөвлөгөөг нь нарийвчилан үнэлэх
- Төлөвлөгөөгөө тайлбарлаж байгаа байдлыг нь үнэлэх
- Амиа хорлох эрсдлийн түвшинг илрүүлэх
- Стресс үүсгэгчүүд, сэтгэлийн өвдөлт, төрх үйлийн өөрчлөлт, нийгмийн дэмжлэгийг нь үнэлэх

Амиа хорлох эрсдлийг илрүүлэх богино хэмжээний сорил

| Өнгөрсөн сард чи: | | Тийм | Үгүй |
|---|---|---|------|
| 1. | Сэтгэл зүйн хямралд орсон уу? Үгүй бол 2-р асуултыг бөглөнө үү, тийм бол 1а асуултыг бөглөнө үү. | | |
| 1а. | Өөрийгөө гэмтээхээр төлөвлөж байсан уу? Үгүй бол 2 бөглөнө үү, тийм бол 1b бөглөнө үү | | |
| 1b. | Сэтгэлийн хямралаас болж үхсэн нь дээр гэж бодож байсан уу? | | |
| 2. | Чи үхсэн нь дээр гэж боддог байсан эсвэл үхэхийг хүсэж байсан уу? | 1 | 0 |
| 3. | Өөрийгөө егүүтгэх, хор учруулах эсвэл гэмтээхийг хүсэж байсан уу? | 2 | 0 |
| 4. | Амиа хорлох тухай бодож байсан уу? | 6 | 0 |
| Тийм бол ямар давтамжтай, хэр хүчтэй энэ тухай бодож байсан бэ? | | | |
| Давтамж | Хүч | Дээрх үйл ажиллагааг өөрийн хяналтанд байлгаж чадах уу? | |
| Хааяа нэг | Бага | 0 | 8 |
| Ойр ойрхон | Дунд | | |
| Байнга | Их | | |
| Өнгөрсөн сард чи: | | | |
| 5. | Амиа хорлох төлөвлөгөөтэй байсан уу? | 8 | 0 |
| 6. | Амиа хорлох аргыг сонгож үхэх оролдлого хийсэн үү? | 9 | 0 |
| 7. | Өөрийгөө егүүтгэхгүй мөртлөө өөртөө гэмтэл учруулж байсан уу? | 4 | 0 |
| 8. | Амиа хорлох оролдлого хийж байсан уу? | 10 | 0 |
| | Амьд үлдэж магадгүй гэсэн бодолтой | | |
| | Үхнэ гэсэн бодолтой | | |

| | | | |
|---------------------------------|---------------------------------------|---|---|
| Чи өөрийнхөө өнгөрсөн амьдралд: | | | |
| 9. | Амиа хорлох оролдлого хийж байсан уу? | 4 | 0 |

- Нэг удаа “Тийм” гэж хариулсан тохиолдолд Амиа хорлох эрсдэлтэй
- 1-8 оноо Амиа хорлох бага эрсдэлтэй
- 9-16 оноо Амиа хорлох дунд эрсдэлтэй
- 17 болон түүнээс дээш Амиа хорлох өндөр эрсдэлтэй

**ГУРАВ. ӨӨРИЙГӨӨ ГЭМТЭЭХ /амиа хорлох эрсдэлийн үнэлгээний шалгуур/
(ДЭМБ, mhGAP)**

Энэхүү шалгуур нь ДЭМБ-ын эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээнд хэрэгжүүлэх mhGAP хөтөлбөрийн эмч эмнэлгийн мэргэжилтнүүдэд зориулсан “Өөрийгөө гэмтээх/ амиа хорлох үйлдэл” модулын үнэлгээ юм.

| № | Үнэлгээний шалгуур | Үнэлэх | Авах арга хэмжээ |
|----|---|---|---|
| 1. | <p>Тухайн хүн ноцтой байдлаар өөрийгөө гэмтээхийг оролдсон уу? Өөрийгөө гэмтээсэн байдлыг нь ажиглаж, үнэлэх:</p> <ul style="list-style-type: none"> • Өөрийгөө хордуулсны илрэл, хордлогын шинжүүдийн илрэлийг тодорхойлох • Яаралтай тусламж үзүүлэх шаардлагатай шинжүүд байгаа эсэхийг тодруул. Үүнд: <ul style="list-style-type: none"> o Өөрийгөө гэмтээсэн шархнаас цус алдаж байгаа эсэх o Ухаан алдаж байгаа эсэх o Хэт нойрмог, унтаа байдалд байгаа эсэх • Ойрын хугацаанд өөрийгөө хордуулах эсвэл өөр аргаар өөрийгөө гэмтээж байсан эсэхийг тодруулан асууна. | <p>Тийм: Хэрэв өөрийгөө гэмтээсэн үйлдлийнх нь улмаас тухайн хүнд эмнэлгийн яаралтай тусламж нэн даруй шаардлагатай байгаа бол</p> <p>Үгүй: Тухайн хүнд өөрийгөө гэмтээх буюу амиа хорлох эрсдэл байхгүй бол</p> | <ul style="list-style-type: none"> • Гэмтэл, хордлогын байдалд нь зохих эмнэлгийн тусламж үзүүлэх • Шавьж устгах хорын цочмог хордлого илэрч байвал зохих зааврын дагуу арга хэмжээ авах • Хэрэв шаардлагатай бол тухайн хүнийг амиа хорлох эрсдлээс сэргийлж, хянах зорилгоор эмнэлэгт үргэлжлүүлэн хэвтүүлэх • Ямар ч тохиолдолд тухайн хүнийг ганцааранг нь үлдээхгүй, аль болох эмнэлгийн нөхцөлд аюулгүй тайван орчинг бүрдүүлсэн өрөөнд байлгах • Сайн асарч, дэмжлэг үзүүлэх • Нийгэм сэтгэлзүйн дэмжлэгийн идэвхтэй үйл ажиллагаанд хамруулах • Боломжтой бол мэргэжлийн сэтгэл зүйч, сэтгэцийн эмч нарын зөвлөгөө авах • Тогтмол хяналтад авч байнгын холбоотой байх |
| 2. | <p>Тухайн хүн ойрын хугацаанд өөрийгөө гэмтээх эсвэл амиа хорлох эрсдэлтэй байна уу? Тухайн хүнээс өөрөөс нь эсвэл асран хамгаалагчаас нь дараах зүйлийг асууж тодруулна уу. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Яг одоо өөрийгөө гэмтээх эсвэл амиа хорлох тухай бодож, төлөвлөж байгаа эсэх | <p>Тийм:</p> <ul style="list-style-type: none"> • Одоогоор өөрийгөө гэмтээх эсвэл амиа хорлох талаар бодож төлөвлөж байгаа бол • Сүүлийн нэг сард өөрийгөө гэмтээх эсвэл амиа хорлох талаар бодож төлөвлөж байгаа эсвэл сүүлийн нэг жилд ийм | <ul style="list-style-type: none"> • Өөрийгөө гэмтээх арга хэрэгслийг нь холдуулах • Аль болох аюулгүй, тайван ээлтэй орчин бүрдүүлсэн, тусгаарлагдсан өрөөнд байлгах • Ганцааранг нь үлдээхгүй байх • Эмнэлгийн ажилтан, эсвэл найз нөхөд, гэр бүл, асран хамгаалагч хэн нэгнийг хажууд нь байлгах |

| | | | |
|----|---|--|--|
| | <ul style="list-style-type: none"> • Өнгөрсөн нэг сард өөрийгөө гэмтээх эсвэл амиа хорлох тухай бодох, эсвэл өнгөрсөн нэг жилд өөрийгөө гэмтээх эсвэл амиа хорлохыг оролдож байсан эсэх • Өөрийгөө гэмтээх эсвэл амиа хорлох аргыг тодруулах • Сэтгэлзүйн хүнд дарамт шахалт бий эсэх • Итгэл найдвараа алдсан эсэх • Хэтэрхий дошгирч байгаа эсэх • Хүчирхийлэлд өртсөн эсэх • Харилцах боломжгүй, ойлгомжгүй байдалтай байгаа эсэх • Бусдаас зожигрож байгаа эсэх | <p>оролдлого хийж байсан бол</p> <ul style="list-style-type: none"> • Одоогоор маш их дошгирсон, сэтгэлийн дарамтанд орсон, харилцах, ойлголцох боломжгүй байгаа бол <p>Энэ хүн өөрийгөө гэмтээх эсвэл амиа хорлох эрсдэлтэй байна</p> <p>Үгүй:</p> <ul style="list-style-type: none"> • Тухайн хүнд өөрийгөө гэмтээх буюу амиа хорлох эрсдэл байхгүй байгаа бол | <ul style="list-style-type: none"> • Сэтгэцийн байдал, сэтгэлзүйн хямралыг үнэлэх • Нийгэм сэтгэлзүйн дэмжлэгийн идэвхитэй үйл ажиллагаанд хамруулах • Боломжтой бол мэргэжлийн сэтгэлзүйч, сэтгэцийн эмч нарын зөвлөгөө авах • Тогтмол хяналтанд авч байнгын холбоотой байх <ul style="list-style-type: none"> • Нийгэм сэтгэлзүйн дэмжлэгийн идэвхтэй үйл ажиллагаанд хамруулах • Боломжтой бол мэргэжлийн сэтгэл зүйч, сэтгэцийн эмч нарын зөвлөгөө авах • Тогтмол хяналтад авч байнгын холбоотой байх |
| 3. | <p>Тухайн хүн мэдрэл, сэтгэцийн ноцтой эмгэг, эсвэл мансууруулах эм бодис хэрэглэх эмгэгтэй байна уу?</p> <p>Тухайлбал: Сэтгэл гутрах эмгэг, архи ба мансууруулах эм бодис хэрэглэх эмгэг, 2 туйлт эмгэг, солиорох эмгэг, Эпилепси, Төрх үйлийн эмгэгүүд</p> | <p>Тийм: Хэрэв ийм ноцтой эмгэг, хүндрэл байгаа бол</p> | <ul style="list-style-type: none"> • Амиа хорлох, өөрийгөө гэмтээхэд хүргэж болохуйц ноцтой эмгэг хүндрэлийг зохих аргачлалын дагуу эмчлэх |
| 4. | <p>Тухайн хүнд архаг өвдөлт байна уу?</p> | <p>Тийм: Хэрэв архаг өвдөлт байгаа бол</p> | <ul style="list-style-type: none"> • Өвдөлтийг намдаан, холбогдох өвчин эмгэгийг нь эмчлэх |
| 5. | <p>Тухайн хүнд эмнэлгийн тусламж зайлшгүй шаардлагатай сэтгэл санааны ноцтой хүнд шинжүүд илэрч байна уу?</p> <ul style="list-style-type: none"> • Ажил, хичээл сургуульдаа явах, олон нийтийн үйл ажиллагаанд оролцоход түвэгтэй байх | <p>Тийм: Хэрэв эмнэлгийн тусламж шаардлагатай шинжүүд илэрч байгаа бол</p> | <ul style="list-style-type: none"> • Холбогдох аргачлал, зааврын дагуу тусламж үйлчилгээ үзүүлэх |

| | | |
|---|--|--|
| <ul style="list-style-type: none"> • Тусламж хайх, сэтгэлийн хямралаа тодорхойлохыг оролдох • Сэтгэлийн хямрал, тайлбарлаж боломгүй зовиураа намдаахын тулд өөрөө дур мэдэн эм хэрэглэх | | |
|---|--|--|

ДӨРӨВ. АМИА ХОРЛОЖ БОЛЗОШГҮЙ ӨСВӨР ҮЕИЙНХЭНД ҮЗҮҮЛЭХ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

4.1. Амиа хорлох оролдлого хийсэн өсвөр үеийнхэнд үзүүлэх сэтгэлзүйн тусламж үйлчилгээ

Хэрэв өсвөр насны хүүхэд амиа хорлох оролдлого хийсэн бол амь насанд ямар аюул учирснаас хамаарч нарийн мэргэжлийн эмчийн яаралтай тусламж үзүүлж, хүүхдийг харьцангуй тайвширсны дараа сэтгэл засал эмчилгээ хийнэ.

Амиа хорлох оролдлого хийсэн хүмүүс нь өөрийгөө “үхэж чадаагүй азгүй хүн” гэсэн мэдрэмж төрөх нь их байдаг бөгөөд дахиад хэзээ ч амиа хорлох оролдлого хийхэд бэлэн байдаг. Иймд сэтгэлзүйн зөвлөгөө, сэтгэл засал эмчилгээг цаг алдалгүй, зайлшгүй хийх шаардлагатай.

Сэтгэлзүйн хямралтай байгаа хүмүүст сэтгэлзүйн яаралтай тусламж үйлчилгээг үзүүлнэ. Энэхүү эмчилгээг сэтгэлзүйн хямралын үеийн сэтгэл засал эмчилгээ гэж нэрлэдэг. Хямралын үеийн сэтгэл засал эмчилгээг ганцаарчилсан буюу хувьчилсан, бүлгийн, гэр бүлийн сэтгэл засал гэсэн хэлбэрүүдээр хийж болно. Сэтгэлзүйн хямралын үеийн сэтгэл засал эмчилгээг 3 үе шаттайгаар явуулна.

Сэтгэлзүйн хямралын үеийн сэтгэл засал эмчилгээний нэгдүгээр үе: Эмч, сэтгэлзүйч, сэтгэл засалч эмч нь үйлчлүүлэгчтэй танилцан өөрт тулгамдсан асуудлынх нь тухай илэн далангүй ярих, үйлчлүүлэгчийн нууцыг хадгалах, эмнэлгийн зүгээс боломжийн хирээр тусламж дэмжлэг үзүүлэх тухай мэдээлэл өгч сэтгэлзүйн холбоо тогтооно. Дараа нь үйлчлүүлэгч өөрт тулгамдсан сэтгэлзүйн асуудлаа бүрэн ярих боломжийг олгож, эмнэлзүйн харилцааны үед баримтлах зарчмын дагуу чөлөөтэй яриулж сэтгэлийн дарамтаас нь чөлөөлнө.

Сэтгэлзүйн хямралын үеийн сэтгэл засал эмчилгээний хоёрдугаар үе: Үйлчлүүлэгчид бий болсон буруу ойлголтыг засах, буруу ойлголтыг нь залруулах, тайлбарлах, ухааруулах арга хэмжээг авна. Өөрийгөө хэнд ч хэрэггүй хүн гэх мэтчилэнгээр буруу төсөөлж байгааг нь ухааруулах, тайлбарлах, сэнхрүүлэх арга замаар засч залруулна.

Сэтгэлзүйн хямралын үеийн сэтгэл засал эмчилгээний гуравдугаар үе: Сэтгэлзүйн хямралтай үйлчлүүлэгчийн буруу төрх үйлийг засах, сатааруулах чиглэлийн сэтгэц нийгмийн нөхөн сэргээх эмчилгээ хийнэ.

Ихэнхи тохиолдолд амиа хорлож болзошгүй үйлчлүүлэгчийг амиа хорлохоос нь урьдчилан сэргийлж сэтгэцийн эмнэлэгт хэвтүүлэн шаардлагатай тусламж үйлчилгээг үзүүлнэ.

Сэтгэц эмгэгийн улмаас амиа хорлох оролдлого хийсэн тохиолдолд үйлчлүүлэгч өөртөө үүсгэсэн гэмтлийн дагуу нарийн мэргэжлийн эмчийн тусламж үзүүлсний дараа сэтгэцийн эмчийн зөвлөгөө авах буюу боломжтой үед сэтгэцийн эмнэлэгт шилжүүлэн эмчилдэг.

4.2. Амиа хорлох эрсдлийн түвшинг үнэлж эрсдэл бүхий өвчтөнд тавих хяналт

| Амиа хорлох эрсдлийн түвшин | Амиа хорлох эрсдлийн үнэлгээ | Хараа хяналтын хэлбэр | Хяналт тавих хугацаа | Хяналтын үргэлжлэх хугацаа | Хяналтыг гүйцэтгэх ажилтан | Сэтгэцийн ажиглалтын дэвтэрт тэмдэглэл хийх |
|-------------------------------|---|----------------------------------|--|----------------------------|---|--|
| Маш өндөр эрсдэлтэй | Урьд нь амиа хорлох оролдлогыг олон удаа хийж байсан, одоогоор амиа хорлоход хүргэж болох нөлөөлөх хүчин зүйлс олон байгаа, эмнэлгийн яаралтай тусламж шаардлагатай. | Байнгын хүчтэй хяналт тавина. | "Гараас гарт" буюу 24 цагийн мөч, хором бүрт | 30-45 минутаас доошгүй | Ээлжийн ахлах Сувилагч | Өдөр 1 удаа, шөнө 1 удаа, ээлж солилцох бүрт |
| Өндөр эрсдэлтэй | Урьд нь амиа хорлох оролдлого хийж байсан, одоо ч амиа хорлох төлөвлөгөөтэй, ирээдүйдээ итгэх итгэлгүй, орчиндоо дасах чадвар алдагдсан. Амиа хорлох тухайгаа бусдад үгээр илэрхийлж байгаа. Амиа хорлоход хүргэж болох нөлөөлөх хүчин зүйл 2 ба түүнээс олон байгаа. | Хатуу хяналт тавина. | Өвчтөн сэрүүн үед "Гараас гарт" хяналт тавих ба өвчтөн унтаж буй үед 15 минут тутамд | 15-30 минутаас доошгүй | Ээлжийн ахлах Сувилагч | Өдөр 1 удаа, шөнө 1 удаа, ээлж солилцох бүрт |
| Дунд зэргийн эрсдэлтэй | Урьд нь амиа хорлох оролдлого хийж байсан, амиа хорлох төлөвлөгөөтэй, амиа хорлоход хүргэж болох нөлөөлөх хүчин зүйл байгаа. Асуудлыг шийдвэрлэхийн тулд бусдаас тусламж авахыг хүсч байгаа. | Байнгын хяналт тавина. | Сэрүүн үед 15 минут тутамд, унтаж буй үед 30 минут тутамд | Шаардлагатай хугацаагаар | Ээлжийн сувилагч Ээлжийн сувилагч | Өдөр 1 удаа, шөнө 1 удаа, ээлж солилцох бүрт |
| Эрсдэлтэй | Урьд нь амиа хорлох оролдлого хийж байсан, амиа хорлох төлөвлөгөөтэй, амиа хорлоход хүргэж болох нөлөөлөх хүчин зүйл байгаа. | Үе үе хяналт тавина. | Өвчтөн сэрүүн буюу унтаж буй үед аль алинд нь 30 минут тутамд | Шаардлагатай хугацаагаар | Ээлжийн ахлах сувилагч, Ээлжийн сувилагч, сувилахуйн сургуулийн төгсөх ангийн оюутан байж болно | Ээлж солилцох бүрт |
| Эрсдэл багатай | Урьд нь амиа хорлох оролдлого хийж байгаагүй, амиа хорлох төлөвлөгөөгүй, амиа хорлоход хүргэж болох нөлөөлөх хүчин зүйл байгаа. | Хааяа буюу ердийн хяналт тавина. | Сэрүүн үед 60 минут тутамд, унтаж буй үед 30 минут тутамд | Шаардлагатай хугацаагаар | Ээлжийн ахлах сувилагч, Ээлжийн сувилагч, сувилахуйн сургуулийн төгсөх ангийн оюутан байж болно | Өдөрт 1 удаа эсвэл шаардлагатай тохиолдолд |

ТАВ. ӨӨРИЙГӨӨ ГЭМТЭЭХ /амиа хорлох оролдлого хийсэн тохиолдолд авах арга хэмжээ/

5.1. Өөрийгөө дүүжлэх аргаар амиа хорлох оролдлого хийсэн тохиолдолд авах арга хэмжээ:

Амиа хорлогсод, амиа хорлох оролдлого хийгчид нь дүүжлэх аргыг хамгийн их хэрэглэдэг. Дүүжлэх үед дүүжлэлтийн улмаас амьсгалын дутагдал хамгийн түрүүнд үүснэ. Дүүжлэх аргыг хэрэглэсэн тохиолдолд ямар хүндрэл үүсэх нь дүүжлэхэд хэрэглэсэн материалын төрөл, дүүжлэлтийн гогцооны байрлал, дүүжлэлтийн сорви хаана үүссэн, хүзүү орчмын эрхтнүүдийн гэмтлийн зэргээс хамаардаг.

Дүүжлэлтийн улмаас амьсгал, зүрх судасны үйл ажиллагаа хямрах ба мөгөөрсөн хоолой, том судсууд, мэдрэлийн зангилаа дарагдан тархины үйл ажиллагаа алдагдана. Дүүжлэлтийн гогцоо нь төвөнхөөс дээгүүр байвал артерийн даралт буурч, тархины хүчилтөрөгч дутагдан муужирч унах ба мэдрэлийн сүлжээ дарагдан шууд амьсгал зогсоно. Харин гогцоо нь төвөнхөөс доогуур байвал амьдралын чухал эрхтнүүдийн үйл ажиллагаа аажмаар муудна.

- Амьсгал боогдсон үед яаралтай гогцоог тайлж амьсгал зүрх судасны тогтолцоог дэмжих эрчимт эмчилгээ хийнэ.
- Венийн судсаар 10%-ийн 10мл кальци хлоридын уусмал, адреналиныг 0.1%-ийн 1 мл тунгаар хийх, эсвэл зүрх зогсох үед 0.5-1 мл уусмалыг цагаан мөгөөрсөн хоолойд гуурсаар хийх буюу 0.1% -ийн 0.5 мл уусмалыг зүрхний ховдолд шууд хийж болно.
- Өвчтөний амьсгалын замыг чөлөөлж амны хөндийг цэвэрлэсний дараа хиймэл амьсгал хийнэ. Хиймэл амьсгал хийх үед хүзүү хугарч болзошгүй тул болгоомжтой хийнэ.

Өвчтөнд тусламж үзүүлэх үед төвөнх хавагнах, хэлэн доорх яс хугарах, мөгөөрсөн хоолой, хүзүү орчмын судас хагарах зэрэг амь насанд аюултай хүндрэл үүсч болно.

5.2. Өөрийгөө хордуулсан тохиолдолд авах арга хэмжээ:

- Нэн даруй хамгийн ойрын эмнэлэгт хандана.
- Хордлогын байдлыг үнэлж, сэхээн амьдруулах зохих арга хэмжээг авах
- Амьсгалын замыг шалган чөлөөлж, шаардлагатай бол хиймэл амьсгалын төхөөрөмж (вентилятор) ашиглана.
- Бөөлжүүлэх
- Ходоод угаах
- Хордлого тайлах, хор саармагжуулах уусмалуудыг венийн судсанд дуслаар хийх гэх мэт шаардлагатай тусламж үйлчилгээг үзүүлнэ.

| № | Хэрэглэсэн эмийн бодис | Эмнэлзүйн шинж тэмдэг | Авах арга хэмжээ |
|----------|----------------------------------|---|---|
| 1. | Бензодиазепинийн цочмог хордлого | Хэт тайвшрах, эмгэг нойронд автах, биеийн тэнцвэр тохироо | - Бөөлжүүлэх - Ходоод угаах - Шээс хөөх түргэн үйлдэл үзүүлэх эм (Лазикс) |

| | | | |
|----|------------------------------|---|---|
| | | алдагдах, ухаан балартах | <ul style="list-style-type: none"> - Хордлого тайлах шингэнүүдийг венийн судсанд дуслаар хийх - Хэрэв сэтгэц хөдөлгөөний дошгирол илэрвэл 2-10 мг тунгаар галоперидол уулгах буюу булчинд тарих |
| 2. | Барбитуратын цочмог хордлого | Ухаан дэмийрэн балартах, сэтгэл хөөрөх хамшинж, уналт таталтын хамшинж, зүрх судасны үйл ажиллагааны дутмагшил, ухаан алдалт | <ul style="list-style-type: none"> - Бөөлжүүлэх - 20-30 гр идэвхижүүлсэн нүүрсийг буцалгасан усанд хольж уулгах - Хордлого тайлах шингэнүүдийг венийн судсанд дуслаар хийх Комын байдалд байвал: <ul style="list-style-type: none"> - Сэхээн амьдруулах өрөөнд шилжүүлэх - Амьсгалын замыг цэвэрлэх - Ходоодыг 0.25%-ын Калийн перманганатын уусмалаар эсвэл идэвхижүүлсэн нүүрс бүхий бүлээн усаар угаах - 0.5%-ын 5-10 мл Бемегридийг судсаар эсвэл 0.1%-ийн 3 мл Стрихининийг судсаар - Хордлого тайлах шингэнүүдийг венийн судсанд дуслаар хийх - Хүчилтөрөгчийг арьсан дор хийх - Глюкозын уусмалыг судсанд тарих - АД хэт буурвал Адреналин хэрэглэх - Цэвэрлэх клизм тавих - Шээс хөөх эм хэрэглэх эсвэл шээсийг катетраар авах - Цус авах |
| 3. | Опиодын цочмог хордлого | Ухаан алдах, ухаан нойрмоглон балартах, амьсгалалт тасалдах буюу амьсгал дарангуйлагдах, АД буурах, зүрхний хэм алдагдах, ХХ нарийсах, сэтгэцийн үйл ажиллагаа буурах | <ul style="list-style-type: none"> - Сэхээн амьдруулах эмчилгээ яаралтай хийх - Антагонистууд хэрэглэх: 0.5%-ийн 1-2 мл Налорфины уусмалыг судсанд тарих, Налоксиныг эмчилгээний эхний 30-45 минутанд 0.4 мг тунгаар 4-5 удаа судсанд тарих - Хордлого тайлах эмчилгээнүүдийг яаралтай хийх - Атрофиныг 0.1%-ийн 1мл-ээр арьсан дор тарих - Хүчилтөрөгчөөр амьсгалуулах - Цитотин эсвэл Лобелин тарихад амьсгал дутмагшил арилахгүй бол хиймэл амьсгал хийх |

| | | | |
|----|---|--|---|
| | | | - Ходоодыг 0.5%-ийн Танины уусмалаар эсвэл 0.02-0.1%-ийн кали перманганатын уусмалаар угаах - Шээсийг катетраар авах |
| 4. | Фенотиазинийн цочмог хордлого (Хлорпромазин, левомепромазин гм) | Хамгийн ноцтой хүндрэл бол Экстрапирамидын хамшинж | - Бөөлжүүлэх - Ходоод угаах - Идэвхижүүлсэн нүүрс хэрэглэх |
| 5. | Салицилитийн цочмог хордлого (Аспирин) | Хамгийн ноцтой хүндрэл бол ацидоз | - Бөөлжүүлэх - Ходоод угаах - Идэвхижүүлсэн нүүрс хэрэглэх - Шээс хөөх эм хэрэглэх - Гемодиализ |

5.3. Өөрийгөө гэмтээсэн хүнийг эмнэлгийн ажилтан асрах

Аль болох аюулгүй, тайван ээлтэй орчин бүрдүүлсэн, тусгаарлагдсан өрөөнд байлгаж, ганцааранг нь үлдээхгүй байхын тулд эмнэлгийн ажилтан, эсвэл найз нөхөд, гэр бүл, асран хамгаалагч хэн нэгнийг хажууд нь байлгана. Хэрэв тухайн хүн эмчилгээ хүлээх шаардлагатай байгаа бол чимээ шуугианаас зайдуу, тусгаарласан өрөөнд байлгахыг хичээнэ.

- Өөрийгөө гэмтээж болох эд зүйлсийг хураан авах
- Боломжтой бол мэргэжлийн сэтгэлзүйч, сэтгэцийн эмчийн зөвлөгөө авах
- Хэрэв СЭМ-ийн мэргэжилтэн байхгүй бол тухайн үйлчлүүлэгчийг гэр бүл, найз нөхөд, эсвэл ойр дотны хэн нэгний байнгын хараа хяналтанд байлган амиа хорлох эрсдлээс сэргийлэх нийгэм сэтгэлзүйн бусад тусламж дэмжлэгийг үзүүлбэл зохино.
- Үйлчлүүлэгч, түүнийг асарч буй хүний аль алинд нь тусламж үзүүлэх, тэдний эрхийг хүндэтгэж, нууцлалыг чанд хадгалах шаардлагатай. Учир нь асран хамгаалагч нар ч үйлчлүүлэгчтэй адилхан сэтгэлийн цочрол хямралд өртдөг тул тэдэнд мөн адил тусламж дэмжлэг шаардлагатай болдог.
- Үйлчлүүлэгч болон түүнийг асарч буй хүмүүстэй нэг бүрчлэн уулзаж ярилцаад тэдэнд тулгараад байгаа нөхцөл байдал, дутагдаж буй нийгэм сэтгэлзүйн хэрэгцээ, шаардлагатай тусламж үйлчилгээ зэргийг үнэлэн тогтооно.
- Хэрэв шаардлагатай гэж үзвэл, асран хамгаалагч, үйлчлүүлэгчийн төрөл саданд сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх арга хэмжээ зохион байгуулна.
- Асаргааг үргэлжлүүлэх
- Амиа хорлохоос сэргийлэх зорилгоор ерөнхий мэргэжлийн (сэтгэцийн бус) эмнэлэгт хэвтүүлэх шаардлагагүй. Харин эмнэлгийн нөхцөлд эмчилгээ хийлгэх шаардлагатай үед ойр дотны хүнийг дэргэд нь байлгавал зохино.
- Хэрэв эмийн жор бичиж өгсөн бол:
 - Эмийн тунг хэтрүүлэхээс сэргийлж олон тоогоор бичихгүй, нэг дор бөөнөөр нь уухаас болгоомжлох
 - Богино хугацааны эмчилгээнд хэрэглэх хэмжээгээр эмийн жорыг олгоно.

5.4. Нийгэм сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх

- Тухайн хүүхдэд дэмжлэг үзүүлэх, гэр бүл, асран хамгаалагчдын оролцоог нэмэгдүүлэх
- Ганцааранг нь үлдээхгүй байх
- Тухайн хүүхдийн давуу сайн талыг түшиглэн ойрын тулгараад байгаа асуудлыг хэрхэн даван туулах талаар хамтран ярилцах
- Хэрэв бэлтгэгдсэн мэргэжлийн боловсон хүчин байгаа бол тухайн хүнийг сэтгэл засал эмчилгээнд хамруулах
- Нийгэм сэтгэлзүйн дэмжлэгийн үйл ажиллагааг идэвхижүүлнэ. Тухайлбал,
 - Эрсдэл арилах хүртэлх хугацаагаар үйлчлүүлэгчийг гэрийн орчинд нь, ойр дотны хүмүүсийнх нь байнгын хараа хяналтанд байлгах
 - Амиа хорлохоор бодож, төлөвлөж, эсвэл завдаж байгаа хүний эргэн тойронд ашиглаж болохуйц эд зүйлс (олс, уяа, шавьж, мэрэгчдийн хор, бусад хорт бодисууд, эм, галт зэвсэг гм)-ийг ойр байлгахгүй далд хийх
 - Олон нийтийн үйл ажиллагаа, тухайлбал гэр бүл, найз нөхөд, хамт олны дунд шаардлагатай мэдээлэл, боловсролын арга хэмжээ зохион байгуулах, шашны төлөөлөгч, нэр хүндтэй хүмүүсээр зөвлөгөө өгүүлэх, орон нутгийн СЭМ-ийн ажилтан, сэтгэлзүйн зөвлөгөө заслын төвд хандах боломжтойг ойлгуулах
 - Сэтгэлийн таагүй мэдрэмж, түгшилт, сэтгэл зовоосон асуудлаа бусадтай хуваалцахыг санал болгох
 - Урьд нь амиа хорлох, өөрийгөө гэмтээх оролдлого хийж байсан эсэхийг гэр бүлийнхэн, найз нөхөд, ойр дотны хүмүүсээс нь асууж тодруулаад дахин ийм үйлдэл хийж болзошгүйг тэдэнд анхааруулна.
 - Асран хамгаалагч нар сэтгэлийн дарамт, ядаргаанд ордог тул тэдэнд зохих дэмжлэгийг үзүүлнэ.
 - Үүссэн нөхцөл байдалд хэт шүүмжлэлтэй хандах, үйлчлүүлэгчийн хийсэн үйлдлийг буруушаах, ойр дотны хүмүүсийг нь ялгаварлан гадуурхахаас зайлсхийвэл зохино.
 - Асран хамгаалагч нар ч шаналж, ичих зовох, айж болгоомжлох байдалд ордог тул тэднийг сэтгэл санаагаар өөдрөг байлгах, дэмжиж туслах хэрэгтэй.
- Идэвхитэй хянах, тогтмол холбоотой байх
 - Тогтмол холбоо барих боломжийг бүрдүүлж (гэрийн утас, гар утасны дугаарыг нь тэмдэглэж авах, гэрийн эргэлт хийх, нэрийн хуудсаа өгөх гм) эхний 2 сарын турш долоо хоног бүр уулзаж байх. Цаашдаа тухайн хүний байдал сайжрахын хирээр уулзалтын давтамжаа цөөрүүлэн 2-4 долоо хоногт 1 удаа уулзаж болно. Шаардлагатай гэж үзвэл үргэлжлүүлэн холбоотой байх хэрэгтэй.
 - Амиа хорлох эрсдэл арилтал идэвхитэй хяналтандаа байлгана. Уулзалт бүрийн үеэр амиа хорлох, өөрийгөө гэмтээх бодол санаа, төсөөлөл байгаа эсэхийг үнэлвэл зохино.

5.5. Амиа хорлох эрсдэлтэй хүүхэд, өсвөр үеийнхэнд зөвлөгөө өгөх, харилцах үедээ баримтлах зарчмууд

5.5.1. Амиа хорлох магадлалтай үйлчлүүлэгчид зөвлөгөө өгөхдөө дараах дүрмүүдийг баримтална.

1. Үйлчлүүлэгчтэй ярилцахдаа өөрийгөө танилцуулан танд туслахад бэлэн гэдгээ биеийн хэлээр болон үг яриагаараа илэрхийлнэ
2. Таны нууцыг хадгалах тул та өөрт тулгамдсан асуудлаа аль болох ярихыг хичээгээрэй, би танд боломжоороо туслах болно гэдгээ илэрхийлнэ
3. Амиа хорлох эрсдэлтэй үйлчлүүлэгчтэй ярилцах цаг аль болох хангалттай байх ёстой. Хүүхэдтэй ярилцаж байгаа бол наснаас хамааран 20-40 минут ярилцдаг. 40-50 минутаас дээш хугацаагаар ярилцах нь үйлчлүүлэгч болон зөвлөгч хэн хэнд нь анхаарал суларч ядардаг тул нэг удаад үүнээс илүү хугацаагаар ярилцах шаардлагагатай.
4. Олонхи тохиолдолд сэтгэлзүйн зөвлөгөө өгөхдөө үйлчлүүлэгч болон ар гэрийнхэнтэй тусдаа уулзах. Шаардлагатай бол ярилцлагын төгсгөлд хамтад нь зөвлөгөө өгөх хэрэгтэй.
5. Амиа хорлох эрсдэл өндөртэй байгаа тохиолдолд эмнэлгийн гадуурх уулзалтыг давтан хийхээс зайлсхийх. Өөрөөр хэлбэл цаг хугацаа алдаж эрсдэлд орж болзошгүй.
6. Үйлчлүүлэгчийн сэтгэлзүй, сэтгэцийн байдал нь эмнэлгийн гадуурх уулзалт хийх боломжтой бол дахин уулзах цаг товлох
7. Амиа хорлох магадлалтай үйлчлүүлэгчийн анхаарлыг түүний амьдралын эерэг талууд руу хандуулах нь чухал. Жишээ нь: Та өөрийн хамгийн их хийх дуртай, сонирхдог зүйлийнхээ талаар ярьж өгнө үү?... Хүн ер нь ямар нэг зүйлийн төлөө амьдардаг. Та энэ талаар ямар бодолтой байна вэ?
8. Үйлчлүүлэгч амиа хорлохыг оролдсон эсвэл амиа хорлох эрсдэлтэй байдлыг мэдмэгцээ сандрахгүй байхыг хичээх, сандарсан, сэтгэл тавгүйтсэн байдал гаргахгүй байх хэрэгтэй. Түүний анхаарлыг ямар нэг байдлаар өөр зүйлд сатааруулах, сарниулах оролдлого хийх хэрэгтэй. Амиа хорлох нь танд тулгамдсан асуудлыг шийдэхгүй, нөхцөл байдлыг өөрчлөхгүй. Бүх шашны хувьд амиа хорлох үйлдэл нь хамгийн их нүгэл хэмээн тооцогддог гэдгийг та мэдэх үү?. Та ямар шашинд итгэж, шүтдэг вэ? гэх мэт итгэл үнэмшил, оюун санааны хүчийг ашиглахыг хичээх хэрэгтэй.
9. Үйлчлүүлэгчтэй ярилцах явцдаа аль болох шууд шүүмжлэх, буруушаах хандлага гаргахаас зайлсхийн, түүний мэдрэмж бодол санааг ойлгохыг хичээж буйгаа түүнд мэдрүүлэх хэрэгтэй. Жишээ нь:
 - ... Би таныг сонсож байна. Та энэ тухай ярихыг хүсч байна уу?
 - ... Танд одоо их хэцүү байгаа бололтой...Таны юу мэдэрч байгааг би ойлгохыг хичээж байна...
 - ... Энэ тухай ярих нь тийм ч амар биш, хэцүү гэдгийг би мэднэ..Гэхдээ энэ тухай яривал танд тустай байх болно гэж бодож байна. Та ярих гээд оролдоод үзэх үү...
10. Амиа хорлохыг бодолтой, төлөвлөгөөтэй хүнтэй хэцүү нөхцөл байдлынх нь талаар аль болох дэлгэрэнгүй ярилцан, эрсдлээс гарах хувилбарыг олох, асуудлаа шийдвэрлэх өөр олон арга зам, боломжуудын тухай ярилцахад анхаарлыг хандуулвал зохино.
11. Амиа хорлох нь бусад ойр дотны хүмүүст шаналал үүсгэж үе тэнгийхэнд сөрөг суртал болдог гэдгийг тайлбарлах
12. Үйлчлүүлэгчийн сэтгэл санааны дарамттай байдал, гэм буруутай гэх мэдрэмж, хорсол занал зэрэгт бүү гайх.

Нууцлалын хязгаарлалт:

- Хэрэв хүн амиа хорлох гэж байгаа бол бүрэн нууцлах албагүй. Тухайн хүнээс, түүний “нууц”-ыг нээлттэй болгох зөвшөөрөл авах нь чухал. Гэхдээ хэрэв үйлчлүүлэгч бусдад нөхцөл байдлыг хэлэхээс татгалзсан бол та түүний аюулгүй байдлыг хангахад туслах боломжтой эрх бүхий мэргэжлийн хүмүүст, тухайлбал хуулийн болон цагдаагийн ажилтан, сэтгэлзүйч, эмнэлгийн удирдлага, хүүхэд хамгааллын ажилтан гэх мэт хүмүүст нууцыг нь задлан хэлж болно. (Хувь хүний нууцын тухай хууль; 3-р бүлэг, 6-р зүйл)

5.5.2. Амиа хорлох эрсдэлтэй өсвөр үеийнхнээс асуух асуултууд:

Сэтгэл зүйн тулгамдсан асуудалтай өсвөр үеийнхэнтэй ярилцлага хийж байгаа хүн бүхний мартаж болохгүй зүйл бол амиа хорлох бодол байгаа үгүйг тодорхой мэдээгүй байгаа бол зарим асуултуудыг шууд асуухаас зайлсхийх хэрэгтэй. Учир нь амиа хорлох бодолгүй хүүхдэд сэдэл өгч болзошгүй. Тиймээс өсвөр үеийнхэнтэй ярилцахдаа өөрийгөө гэмтээх/амиа хорлох талаар асуухдаа тухайн асуудалд хүргэсэн цэгээс тохирох шилжилтийг хийж асуулт асуух хэрэгтэй. Жишээлбэл: Эхлээд тухайн хүний таагүй мэдрэмжийг тодруулж, дараа нь өөрийгөө гэмтээх төлөвлөгөө бий эсэхийг тодруулах:

- Чамайг маш хэцүү үеийг туулж байгааг би ойлгож байна. Ихэнхи хүмүүс ийм байдалд орохоороо амьдрал үнэ цэнэгүй юм шиг мэдэрдэг. Чамд урьд өмнө нь ийм мэдрэмж төрж байсан уу?

Амиа хорлох бодол, төлөвлөгөөний талаарх ерөнхий асуултууд:

- Чиний амьдралыг үнэ цэнэгүй болгодог ямар зүйлс байдаг вэ?
- Чиний амьдралыг үнэ цэнэтэй болгодог ямар зүйлс байдаг вэ?
- Чи хэзээ нэгэн цагт амьдралаа дуусгахыг хүсч байсан уу?
- Чи хэзээ нэгэн цагт өөрийгөө гэмтээх талаар бодож байсан уу?
- Чи өөрийгөө гэмтээх талаар хэрхэн бодож байсан бэ? Чи юу хийх байсан бэ?

Амиа хорлох бодол, төлөвлөгөөний талаарх өвөрмөц асуултууд:

- Чамд өөрийгөө гэмтээх талаар ямар бодол төрж байсан бэ?
- Чамд дээрх бодлууд хэр удаан бодогдож байна вэ?
- Тухайн бодол хэр хүчтэй байсан бэ? Хэр олон удаа, ямар хугацаагаар үргэлжилдэг вэ?
- Эдгээр бодлууд сүүлийн үед нэмэгдэж байна уу?
- Чамд амиа хорлох эсвэл өөрийгөө гэмтээх төлөвлөгөө байна уу?
- Ямар төлөвлөгөө байна вэ? Чи үүнийг хаана хийх вэ? Чи үүнийг хэзээ хийх вэ?
- Чамд төлөвлөгөөгөө хэрэгжүүлэх арга хэрэгсэл байгаа юу?
- Чамд буу, олс гэх мэт аргуудын аль нь амархан бэ?
- Чи урьд өмнө нь ямар нэгэн оролдлого хийж байсан уу? Хэрэв тийм бол юу болсон бэ?

Хамгаалах хүчин зүйлсийг тодруулах асуултууд:

- Чиний амьдралыг ямар зүйлс үнэ цэнэтэй болгодог вэ?
- Чи өмнө нь үүнтэй төстэй байдалд орохдоо хэрхэн даван туулж байсан бэ?
- Өнгөрсөн хугацаанд чамд юу туслаж байсан бэ?
- Чи хэнээс тусламж хүсдэг вэ? Чамайг хэн сонсдог вэ? Чамайг хэн дэмжиж байгааг мэдэрдэг вэ?
- Чиний амьдралд юу өөрчлөгдвөл чиний амиа хорлох бодол өөрчлөгдөх вэ?

5.5.3. Нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээнд илгээх заалт

- Ганц нэг удаагийн ярилцлагаар асуудлыг шийдвэрлэх боломжгүй тохиолдолд
- Үйлчлүүлэгчид сэтгэл засал эмчилгээ шаардлагатай
- Үйлчлүүлэгчид оношлогоо, эмийн эмчилгээ шаардлагатай тохиолдолд
- Үйлчлүүлэгчид эмнэлгийн хараа хяналт шаардлагатай тохиолдолд
- Мэргэжлийн тусламжинд хандах зөвшөөрлийг тухайн хүнээс авсан тохиолдолд
- Мэргэжлийн тусламжинд илгээх шаардлагатай мэдээлэл олж авсан бол
- Тусламж үзүү
- лэх боломжтой байгууллагыг тодорхойлох
- Илгээх бичгийг үйлдэх
- Тусламжинд хандсан эсэхэд хяналт тавих, эргэх холбоо тогтоох
- Цөөн тохиолдолд үйлчлүүлэгч сэтгэцийн эмгэгийн улмаас эмнэлэгт хандахыг зөвшөөрөхгүй байгаа бол албадан эмчилгээнд хамруулна.

5.5.4. Утсаар зөвлөгөө өгөх үед анхаарах зүйлс:

1. Амиа хорлох аливаа бодол санаа илэрч буй тохиолдолд тухайн асуудалд нухацтай хандах хэрэгтэй.
 - Амиа хорлохыг хүсч байгаа тухай мэдэгдэл бүр нь тухайн хүний сэтгэл өвдөлтийн илэрхийлэл байдаг тул амиа хорлохыг бодож буй хүмүүс амьдралаа дуусгахаар төлөвлөж байгаа эсэхээс үл хамааран мэргэжлийн туслалцаа авах шаардлагатай болохыг хэлж ойлгуулах хэрэгтэй. Үүний тулд:
 - ✓ Амиа хорлохыг бодож буй хүн шүүмжлүүлэх эсвэл үл тоомсорлогдохоос илүү хүлээн зөвшөөрөгдсөн мэдрэмжийг мэдрэхийг эрмэлздэг гэдгийг анхаарах
 - ✓ Хийх гэж буй үйлдэлдээ урьдчилан бэлтгэсэн, төлөвлөсөн хүнд туслахад зөвлөгчийн боломж хязгаарлагдмал байдгийг мэдэж байх нь чухал юм.
 - ✓ Тусламж дэмжлэг хайж буй эсэхийг тодруулж мэдэх хэрэгтэй.
 - “Гурвын дүрэм”-ийг баримтлах: Амиа хорлох бодолтой хүнд туслах 3-аас доошгүй хүн хэрэгтэй байдаг.
2. Нөхцөл байдал хир ноцтой байгаа эсэхийг тодорхойлох хэрэгтэй. Тухайлбал:
 - Амиа хорлохыг хүсч буй хүнээс амиа хорлох холбоотой асуултыг шууд асуух нь амиа хорлох зан үйлийг өдөөдөггүй. Амиа хорлохоор төлөвлөсөн хүн төлөвлөгөөгөө хэрэгжүүлэхийг тэр бүр яардаггүйг санаж байх

- Тухайн хүнд тус болох бүх хүмүүстэй аль болох хурдан холбоо бариарай (жишээ нь: цагдаа гм).
3. Амиа хорлохыг бодож буй хүнтэй харилцахдаа:
- Үр дүнтэй үг хэллэг ашиглах
 - ✓ "..тэгэх ёстой" ба ".. тэгж болохгүй" гэх зэргээр санаагаа илэрхийлэхээс зайлсхийх.
 - ✓ Тухайн хүнд зөвлөх биш, тухайн хүнтэй харилцан ярилцахыг хичээх. "Лекц унших"-аас зайлсхийх.
 - Санал бодлоо хуваалцах аюулгүй орчинг бүрдүүлэх
 - ✓ Дуудлага тасалдахааргүй, аюулгүй орчинд ярилцах боломжтойг ойлгуулах.
 - ✓ Зөвлөгчийн дуу хоолой зөөлөн дулаан, анхаарал халамжтай мэдрэмжийг төрүүлэхүйц, яриа ойлгомжтой тодорхой бөгөөд тайван зэрэг сэтгэгдэл мэдрүүлэхүйц байвал зохино.
 - Амиа хорлох талаар бодож буй хүний сэтгэлийн зовлонг хүлээн зөвшөөрөх.
 - Туслахад бэлэн байгаагаа илэрхийлэх
 - Бодитой хандах
 - ✓ Амиа хорлохыг хүсч буй тухайн хүн бодит байдалтай нийцэхгүй, уурлаж магадгүй юм. Гэхдээ мэдрэмжээ нээлттэй илэрхийлэхэд нь аль болох туслаж асуудалд бодитой хандах боломжийг олгох
 - ✓ Чимээгүй байж, илүү их сонс, бага ярь.
4. Юуг хийж болохгүй вэ?
- Амиа хорлолтын тухай ярихаас бүү ай. Нөхцөл байдлыг бодитоор шийдвэрлэх нь нэн чухал гэдгийг санаж байх.
 - Тухайн хүний мэдрэмж бодол санааг үгүйсгэх, өөрийн зөвийг нотлох гэж бүү марга, бүү оролд.
 - Түүнийг байгаагаас нь илүү тайвшруулах гэж хүчлэх хэрэггүй.
 - Түүний мэдрэмжийг бүү бууруул.
5. Амиа хорлох магадлалын түвшинг тодорхойлохдоо зөвлөгч шууд чиглэсэн асуултаас зайлсхийн дам асуулт тавьж илрүүлэх